



**Ш.ЭНХЖАРГАЛ**  
ХСИС-ийн Шүүхийн  
шийдвэр гүйцэтгэлийн  
сургуулийн Шийдвэр  
гүйцэтгэлийн тэнхимийн  
багш, хууль зүйн  
магистр, хошууч

## ШИНЭ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

**Хураангуй:** Монгол улс дахь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн ялын бодлогод орсон хорих ялын өөрчлөлтийн талаар онцлон судалсан.

Монгол Улсад хамгийн анхны Эрүүгийн хуулийг 1926 онд "Шүүх цаазын бичиг" хэмээх нэртэйгээр батлан гаргаснаас хойш 1929, 1934, 1942, 1951, 1961, 1987, 1993, 2002 онуудад өөрчлөн шинэчилж байжээ. Тухайн үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой эрүүгийн хууль уялдаж байсан. Тухайлбал, 1987 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад зарчмын шинжтэй хэд хэдэн өөрчлөлтийг оруулж байжээ. Тухайн үед амины болон социалист гэсэн өмчийн хоёрхон хэлбэрийг зөвшөөрч байсан билээ. Гэтэл Японы Элчин сайдын яамнаас хоёр ширхэг булган малгай алдагдсан хэрэг гарчээ.

Хэргийг шийдвэрлэх гэтэл тухайн үеийн эрүүгийн хуульд капиталист өмчийн тухай заалт байгаагүй учир гацаанд орж байсан гэдэг. Дараа нь Гандантэгчинлэн хийдэд хулгай орсныг бас л өмчийн хэлбэрийг нь тогтоож чадаагүй учраас шийдвэрлэж чадаагүй байна. Иймд 1987 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад гадаад улсын өмчийн болон шашны болон олон нийтийн өмчийн эсрэг гэмт хэрэг гэсэн зүйл заалтыг нэмж оруулж байжээ.<sup>1</sup>

Харин 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр сонгогчид... -“2002 оны Эрүүгийн хуулийн хууль амьдралд нийцэхгүй байгаа талаар...” үзэл бодлоо УИХ-ын гишүүнд нэр дэвшигчдэд олонтаа илэрхийлж байсан байна. Хуульчид ч бас эрүүгийн хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлага байгааг дурьдаж байсан.

2002 оны Эрүүгийн хууль нь зарим талаар шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял сонгож хэрэглэх боломжийг алдагдуулж, эрүүгийн хуульд бичсэн ялыг л шийтгэхдээ тогтоолдоо бичихээс өөр аргагүй байдалд хүргэж, монголын нийгэмд шоронжих үйл явцын хөрс суурийг тавьсан юм.<sup>2</sup> гэж үздэг.

<sup>1</sup> <http://amnesty.mn/files/aim/docs/files/2010/03/file-57.pdf>

<sup>2</sup> Шинэчилсэн эрүүгийн хуулийн төсөл санаачлагчид

Ийм учраас Эрүүгийн хуулийн шинэ бодлогод хорих ялын тоог бууруулах, хорихоос өөр төрлийн ял оноох хэлбэрийг сонгох замыг баримталсан гэж хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийнхэн хэлжээ. Энэхүү тайлбар бодит байдалд хэрхэн нийцсэн талаар судалж үзэхэд;

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд 238 гэмт хэрэг байгаагаас 209 гэмт хэрэгт хорих ял оногдуулсан, 29 гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял дагнан оногдуулсан байна. Хүснэгтээр дэлгэрэнгүйгээр харуулбал:


| Д/д         | Гэмт хэргийн төрөл                                                                       | Хамаарах гэмт хэрэг | Хорих ял оноосон гэмт хэрэг | Хорихоос өөр төрлийн ял оноосон гэмт хэрэг |
|-------------|------------------------------------------------------------------------------------------|---------------------|-----------------------------|--------------------------------------------|
| 1           | Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг                                                | 13                  | 13                          | 0                                          |
| 2           | Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг                                            | 17                  | 15                          | 2                                          |
| 3           | Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг                            | 6                   | 5                           | 1                                          |
| 4           | Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг                                 | 16                  | 14                          | 2                                          |
| 5           | Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг                       | 16                  | 7                           | 9                                          |
| 6           | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг                                                           | 13                  | 10                          | 3                                          |
| 7           | Аж ахуйн эсрэг гэмт хэрэг                                                                | 25                  | 24                          | 1                                          |
| 8           | Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг                                                | 18                  | 17                          | 1                                          |
| 9           | Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг                                                  | 10                  | 10                          | 0                                          |
| 10          | Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг                                                | 14                  | 14                          | 0                                          |
| 11          | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 11                  | 11                          | 0                                          |
| 12          | Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг                                 | 4                   | 4                           | 0                                          |
| 13          | Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг                                                       | 15                  | 11                          | 4                                          |
| 14          | Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг                                                 | 18                  | 14                          | 4                                          |
| 15          | Албан тушаалын гэмт хэрэг                                                                | 12                  | 10                          | 2                                          |
| 16          | Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг                                                          | 22                  | 22                          | 0                                          |
| 17          | Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энхтайваны эсрэг гэмт хэрэг                              | 8                   | 8                           | 0                                          |
| <b>Нийт</b> |                                                                                          | <b>238</b>          | <b>209</b>                  | <b>29</b>                                  |

Шинээр батлагдсан Эрүүгийн хуульд 206 гэмт хэрэг байгаагаас 206

гэмт хэрэгт хорих ял оногдуулахаар хуульчилсан байна.

| Д/д         | Гэмт хэргийн төрөл                                                                 | Хамаарах гэмт хэрэг | Хорих ял оноосон гэмт хэрэг | Хорихоос өөр төрлийн ял оноосон гэмт хэрэг |
|-------------|------------------------------------------------------------------------------------|---------------------|-----------------------------|--------------------------------------------|
| 1           | Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг                                            | 6                   | 6                           | 0                                          |
| 2           | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг                             | 7                   | 7                           | 0                                          |
| 3           | Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, гэмт хэрэг                       | 5                   | 5                           | 0                                          |
| 4           | Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг                             | 13                  | 13                          | 0                                          |
| 5           | Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг                        | 9                   | 9                           | 0                                          |
| 6           | Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг                                                     | 6                   | 6                           | 0                                          |
| 7           | Хүүхдийн эсрэг гэмт хэрэг                                                          | 11                  | 11                          | 0                                          |
| 8           | Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг                                                     | 12                  | 12                          | 0                                          |
| 9           | Эдийн засгийн гэмт хэрэг                                                           | 13                  | 13                          | 0                                          |
| 10          | Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг                                          | 17                  | 17                          | 0                                          |
| 11          | Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг                       | 16                  | 16                          | 0                                          |
| 12          | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг                                | 14                  | 14                          | 0                                          |
| 13          | Авлигын эсрэг гэмт хэрэг                                                           | 12                  | 12                          | 0                                          |
| 14          | Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг                                     | 7                   | 7                           | 0                                          |
| 15          | Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг                                             | 9                   | 9                           | 0                                          |
| 16          | Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг                                                      | 6                   | 6                           | 0                                          |
| 17          | Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг                                  | 3                   | 3                           | 0                                          |
| 18          | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг | 11                  | 11                          | 0                                          |
| 19          | Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг                                                    | 19                  | 19                          | 0                                          |
| 20          | Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энхтайваны эсрэг гэмт хэрэг                        | 10                  | 10                          | 0                                          |
| <b>Нийт</b> |                                                                                    | <b>206</b>          | <b>206</b>                  | <b>0</b>                                   |





Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд нийт гэмт хэргийн 12,2%-д хорихоос өөр төрлийн ял дагнан оногдуулахаар заасан бол, шинээр батлагдсан эрүүгийн хуульд 100% хорих ял оногдуулсан санкцитай байна. Энэхүү судалгаанаас харахад нийгмийг шоронжих байдлаас

гаргана гэсэн зорилгодоо хүрч чадаагүй байна гэж үзэж болохоор байна.

Шинэ Эрүүгийн хуулийн ялын төрөлд баривчлах ялыг хассантай холбогдуулан хорих ялын хэмжээ 7 хоногоос 20 жил, цаашлаад бүх насаар нь хорихоор хуульчилжээ.

| Д/д | 7 хоногоос эхлэн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг                  | 1 сараас эхлэн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | 3 сараас эхлэн хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг                           | Бүх насаар нь хорих ял оногдуулсан гэмт хэрэг                     |
|-----|----------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------|
| 1   | 11.6, 11.7, 13.5, 13.6, 16.7, 17.1, 17.5, 17.11, 20.15, 21.8, 24.6, 28.13. | 10.5, 11.2, 11.3, 11.4, 11.5, 12.2, 12.4, 12.5, 13.7, 13.8, 13.9, 13.10, 13.11, 13.12, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 15.1, 15.2, 16.8, 16.10, 16.11, 17.3, 17.4, 17.7, 17.8, 17.9, 18.2, 18.5, 18.6, 18.10, 18.11, 19.11, 19.13, 19.16, 20.12, 20.14, 21.5, 21.7, 21.9, 21.10, 21.11, 22.2, 22.4, 22.5, 22.10, 22.11, 22.12, 23.1, 23.2, 23.3, 23.4, 23.5, 25.1, 25.2, 25.3, 25.4, 25.6, 27.4, 27.7, 27.10, 27.11, 28.1, 28.3, 28.4, 28.5, 28.6, 28.7, 28.11, 28.14, 28.15, 28.19, 29.2. | 17.2, 18.1, 18.3, 18.8, 18.9, 19.14, 19.15, 19.17, 21.1, 21.2, 21.3, 26.1, 28.10, | 12.1, 19.1, 19.3, 19.4, 19.5, 19.6, 29.1, 29.4, 29.5, 29.7, 29.8. |
| 2   | Нийт 12 гэмт хэрэгт                                                        | Нийт 77 гэмт хэрэгт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Нийт 13 гэмт хэрэгт                                                               | Нийт 11 гэмт хэрэгт                                               |

Сонирхуулж хэлэхэд шинэ Эрүүгийн хуульд 40 гэмт хэрэг шинээр орсон байна. Тухайлбал: баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлэн хүнийг алах-10.3 /одоогийн Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй байгаа/, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх-11.7, заналхийлэх-13.5, албадан хөдөлмөрлүүлэх-13.13, хүүхдийг шийтгэх-16.7, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах-16.9, хууль бусаар газар орны нэр өөрчлөх-19.16, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах-22.12, нисэх багийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох-27.4 гэх мэт заалтууд байна.

Энэхүү судалгаанаас харахад хүнд ба онц хүнд гэмт хэрэг, террорист явуулга, зохион байгуулалттай гэмт явдал үйлдсэн этгээдийн хувьд ялын хатуу чанга байлгах бодлогыг баримталсан байна.